



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/36

Мөрөн сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит IX хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Аймгийн Орон хөгжлийн сан дахь зураг төслийн сангаас санхүүжихээр батлагдсан Халуун усны барилгын зураг төсөв (Арбулаг сум) 23,000,000 (Хорин гурван сая) төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулах, санхүүжилт олгох эрхийг Арбулаг сумын Засаг даргад шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулж, худалдан авах ажиллагааны явцын тайланг 14 хоног тутамд аймгийн Орон нутгийн өмчийн газарт тайлагнаж ажиллахыг Арбулаг сумын Засаг дарга (Б.Гантулга)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН